

МОНГОЛ УЛС

**“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК,  
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК**

болон

**“БОДЬ ИНТЕРНЭШНЛ” ХХК**

нарын хооронд байгуулсан

**БОГДХАН ТӨМӨР ЗАМЫН ТУННЭЛ БОЛОН ЭСТАКАДАН  
ГҮҮРНИЙ ЗУРАГ ТӨСӨЛ, ХУДАЛДАН АВАЛТ, БАРИЛГЫН  
АЖЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭ**

“ТАВАНТОЛГОЙ” ХК  
ХЭЗГ  
№01

Улаанбаатар хот  
2022 он

БОГДХАН ТӨМӨР ЗАМЫН ТУННЭЛ БОЛОН ЭСТАКАДАН ГҮҮРНИЙ ЗУРАГ  
ТӨСӨЛ, ХУДАЛДАН АВАЛТ, БАРИЛГЫН АЖЛЫН  
САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭ

2022 оны 6 дугаар сарын 27 ны өдөр

Дугаар МН-ЭТ-2022/487

Улаанбаатар хот

ТТЗ-МН 22/01




БГ-ВВР-СОНТ-0002

Энэ Богдхан төмөр замын туннел, эстакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г

нэг талаас: “Эрдэнэс Тавантолгой” ХК (РД: 5435528)  
(цаашид “Санхүүжүүлэгч” гэх);  
нөгөө талаас: “Тавантолгой төмөр зам” ХХК (РД: 6375405)  
(цаашид “Захиалагч” гэх);  
нөгөө талаас: “Бодь Интернэшнл” ХХК (РД: 2040433)  
(цаашид “Гүйцэтгэгч”, хамтад нь “Талууд” гэх) нар;

УДИРТГАЛ

- i) Санхүүжүүлэгч нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Таван толгойн нүүрсний ордод хамаарах нийт 68,471 /жаран найман мянга дөрвөн зуун далан нэгэн/ гектар талбай бүхий ашигт малтмал ашиглах MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956, MV-016881, MV-016882, MV-016883 тоот тусгай зөвшөөрлийн эзэмшигч мөн тул;
- ii) Санхүүжүүлэгч нь Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Таван толгой төмөр зам” ХХК-ийн 66 /жаран зургаан/ хувийн хувьцаа эзэмшигч мөн тул;
- iii) Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн “Богдхан төмөр зам” төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай 206 дугаар тогтоолоор “Богдхан төмөр зам” төслийн зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын нийт санхүүжилтийг шийдвэрлэхийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д даалгасан болохыг;
- iv) Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн Тусгай зөвшөөрөл олгох тухай 230 дугаар тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д 5 жилийн хугацаатай олгосон болохыг;
- v) Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 254 дугаартай Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д олгосон болохыг;
- vi) Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 353 дугаартай Богдхан төмөр зам төслийг эрчимжүүлэх арга хэмжээний тухай тогтоолоор “Богдхан” төмөр замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг эрх бүхий байгуулагчаар магадлуулсан техник, эдийн




засгийн үндэслэлийн дүнд багтаан нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д даалгасан болохыг тус тус тэмдэглэн;

- vii) Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл;
- viii) Зам тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын хамтарсан Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай 2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн МН-02/МН-235 дугаартай тушаал;
- ix) Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын хамтарсан Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн МН-01, МН/03, МН/28 дугаар хамтарсан тушаал;
- x) Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хурлын 05 дугаар шийдвэр, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр шийдвэр, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ийн 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 100/2022 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр тус тус магадлагдсан “Богдхан төмөр зам”-ын техник, эдийн засгийн үндэслэл;
- xi) “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн Гэрээ байгуулах эрх олгох тухай 28 дугаар тогтоол,
- xii) “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 31 дугаартай Их хэмжээний хэлцэл хийж, гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай тогтоолын 1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн:

Иргэний хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Барилгын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.


### НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ гэрээний зорилго нь “Богдхан төмөр зам” төслийн туннел, эстакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлыг нүүрс урьдчилан борлуулах замаар болон бэлэн мөнгө, бусад эрх үүсвэрээр санхүүжүүлэхтэй холбогдон Талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбоотой үүссэн бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Санхүүжүүлэгч болон Гүйцэтгэгчийн хооронд байгуулагдах Нүүрс нийлүүлэх гэрээ нь энэ гэрээний нэгдмэл, салшгүй нэг жэсэг мөн болно.



## ХОЁРДУГААР ЗҮЙЛ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
- 2.1.1. “талууд” гэж “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Бодь Интернэшнл” ХХК-ийг;
  - 2.1.2. “техник, эдийн засгийн үндэслэл” гэж Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хурлын 05 дугаар шийдвэр, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр шийдвэр, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ийн 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 100/2022 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр тус тус магадлагдсан “Богдхан” төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийг;
  - 2.1.3. “төсөл” гэж гэрээний 2.1.2-т тодорхойлсон техник, эдийн засгийн үндэслэлд заасан “Богдхан төмөр зам”-ын туннел болон эстакадан гүүрний ажлыг;
  - 2.1.4. “ажил” гэж энэ гэрээний дагуу санхүүжилт хүлээн авч техник, эдийн засгийн үндэслэлд заасан “Богдхан төмөр зам”-ын туннел, эстакадан гүүр барьж гүйцэтгэхийг;
  - 2.1.5. “нүүрс нийлүүлэх гэрээ” гэж энэ гэрээний Хавсралт 3-т заасан Санхүүжүүлэгч болон Гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээг;
- 2.2. Энэ гэрээг тайлбарлахад мөн гэрээнд тусгайлан өөрөөр заагаагүй бол дараах дүрмийг баримтална:
- 2.2.1. гэрээний зүйл, хэсгийг гэрээг хэрэглэхэд дөхөм болгох үүднээс гарчигласан бөгөөд ийнхүү гарчигласан нь гэрээний агуулгыг тайлбарлахад нөлөөлөхгүй;
  - 2.2.2. гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол гэрээнд заасан “зүйл”, “хэсэг”, “заалт”, “хавсралт” гэдэгт гэрээний зүйл, хэсэг, заалт, хавсралтыг ойлгоно;
  - 2.2.3. гэрээ болон бусад гэрээ, баримт бичигт дурдагдсан хувь хүн, хуулийн этгээд, байгууллагад тэдгээрийн хууль ёсны болон гэрээний дагуу эрхийг нь залгамжлан авах этгээдийг хамруулан ойлгоно;
  - 2.2.4. гэрээнд заасан хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал, захирамж, удирдамж, заавар, аргачлал болон бусад адилтгах баримт бичигт тэдгээрийн шинэчилсэн найруулга, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлт, тэдгээрийг орлуулан баталсан хувилбарыг хамруулан ойлгоно;
  - 2.2.5. гэрээнд тусгайлан өөрөөр заагаагүй бол нийтээр хүлээн зөвшөөрсөн техникийн болон худалдааны үг, хэллэгийг нийтээр хүлээн зөвшөөрч хэрэглэдэг утгаар нь ойлгоно.




**ГУРАВДУГААР ЗҮЙЛ.**  
**САНХҮҮЖИЛТИЙН НӨХЦӨЛИЙН ТАЛААРХ ҮНДСЭН ТОХИРОЛЦОО**

**3.1. Гэрээний үнэ буюу нийт санхүүжилтийн хэмжээ:**

- 3.1.1. Гэрээний үнэ буюу нийт санхүүжилтийн хэмжээ нь Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хурлын 05 дугаар шийдвэр, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр шийдвэр, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ийн 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 100/2022 дугаар Магадлалын ерөнхий дүгнэлтээр тус тус магадлагдсан “Богдхан” төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 31 дүгээр тогтоолын 1.1-д заасан “Богдхан төмөр зам”-ын туннел, стакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт барилгын ажилд шаардагдах 734,619,823.67 /долоон зуун гучин дөрвөн сая зургаан зуун арван есөн мянга найман зуун хорин гурван доллар жаран долоон цент/ ам.доллараас илүүгүй байна.
- 3.1.2. Энэ гэрээний 3.1.1-д заасан үнэд “Богдхан төмөр зам”-ын туннел, стакадан гүүрний ажилд тавих, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, холбогдох татвар, хураамж, төлбөр гэх мэт ажлыг бүрэн хийж гүйцэтгэхтэй холбоотой зардал багтана.
- 3.1.3. Санхүүжүүлэгч нь энэ гэрээний 3.1.1-д заасан үнийн дүнг энэ гэрээ, Нүүрс нийлүүлэх гэрээ болон бэлэн мөнгө, бусад эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Хэрэв Санхүүжүүлэгч нь төслийн ажлыг бэлэн мөнгөөр санхүүжүүлэх тохиолдолд тухайн санхүүжилтийг Захиалагчийн дансанд шилжүүлнэ.
- 3.1.4. Гэрээний дагуу гүйцэтгэлээр олгосон санхүүжилт нь энэ гэрээний 3.1.1-д заасан үнийн дүнгээр хязгаарлагдана.
- 3.1.5. Санхүүжүүлэгч нь ажлын бүтээн байгуулалтад урьдчилгаа төлбөрийн зориулалтаар аливаа санхүүжилт олгохгүй.

**3.2. Төсөлд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх:**


- 3.2.1. Гүйцэтгэгч нь төслийн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах 3.1.1-д заасан дүнтэй тэнцүү хэмжээний хөрөнгийг урьдчилан санхүүжүүлж, ажлыг төлөвлөгөөт хугацаанд багтаан бүрэн гүйцэтгэж Захиалагчид хүлээлгэн өгнө.
- 3.2.2. Санхүүжүүлэгч нь энэ гэрээний 3.1.1-д заасан санхүүжилтийг өөрийн эзэмшлийн нүүрсний уурхайгаас олборлосон нүүрсийг Гүйцэтгэгч болон түүний нэрлэсэн худалдан авагчид нийлүүлэх замаар “Хавсралт 2”-т заасан хуваарийн дагуу нөхөн төлнө.
- 3.2.3. Нийлүүлэх нүүрсний хэмжээ, үнэ, нүүрс нийлүүлэх хуваарь болон бусад нөхцөлтэй холбогдсон харилцааг энэ гэрээний “Хавсралт 3”-д заасан Санхүүжүүлэгч болон Гүйцэтгэгчийн хооронд байгуулсан Нүүрс нийлүүлэх гэрээгээр зохицуулна.



- 3.2.4. Гүйцэтгэгч нь хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, гүйцэтгэсэн ажлын үнийн мэдээллийг улирал бүрийн эхний 10 хоногт багтаан Санхүүжүүлэгч, Захиалагчид гаргаж өгөх үүрэгтэй.
- 3.2.5. Гүйцэтгэгч нь төсөлд шаардлагатай хөрөнгийг урьдчилан санхүүжүүлэх бөгөөд хөрөнгө босгох үйл ажиллагаа, санхүүжилтийн хуваарь нь “Богдхан төмөр зам”-ын туннел, эстакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээнд заасан ажлыг хуваарийн дагуу аливаа саадгүйгээр хэвийн үргэлжлүүлэх шаардлагыг бүрэн хангасан байна.
- 3.2.6. Гүйцэтгэгч нь энэ гэрээний 3.2.1-д заасан мөнгөн хөрөнгийг зөвхөн Төслийн ажилд захиран зарцуулах үүрэгтэй.
- 3.2.7. Энэ гэрээний 3.1.1-д заасан үнийн дүнд төслийн ажлыг хийж гүйцэтгэх дүн багтсан байх бөгөөд нэмэлт санхүүжилт олгохгүй.
- 3.2.8. Санхүүжүүлэгч нь Гэрээний 3.1.1-д заасан санхүүжилтийг Гүйцэтгэгч болон түүний нэрлэсэн худалдан авагчтай байгуулсан нүүрс худалдах, худалдах авах гэрээнд заасны дагуу олгохдоо ам.доллараар тооцно.
- 3.2.9. Талууд нь ам.доллараар олгосон санхүүжилтийн валютын ханшийг Монгол банкны тухайн өдрийн зарласан албан ёсны ханшаар тооцно.

### 3.3. Тооцоо нийлэх:

- 3.3.1. Талууд нь санхүүжилтийн гүйцэтгэлийн тооцоог улирал бүрийн дараа сарын 10-ны өдөрт багтаан нийлнэ. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр уг өдрийг өөрчилж болно.
- 3.3.2. Гүйцэтгэгч нь тооцоо нийлэх мэдэгдлийг энэ гэрээний 3.3.1-д заасан хугацаанаас ажлын 5 өдрийн өмнө Санхүүжүүлэгч, Захиалагчид хүргүүлнэ.
- 3.3.3. Тооцоо нийлэх мэдэгдэлд дараах зүйлсийг тусгана:
- энэ гэрээний “Хавсралт 3” болох Нүүрс нийлүүлэх гэрээний дагуу тухайн сард хүлээн авах ёстой нүүрсний хэмжээ болон бодитоор хүлээн авсан нүүрсний хэмжээ;
  - нүүрсний үнэ;
  - “Богдхан төмөр зам”-ын туннел болон эстакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээнд заасан хуваарийн дагуу гүйцэтгэсэн ажлын баталгаажсан дүн;
  - ажил гүйцэтгэх хуваарийн дагуу гүйцэтгэсэн ажлын хүлээгдэж буй үнийн дүн;
  - захиалагчийн хяналтын зардал;
  - шаардлагатай бусад.
- 3.3.4. Гүйцэтгэгч нь “Богдхан төмөр зам”-ын туннел болон эстакадан гүүрний барилгын ажлын үр дүнг улсын комисст хүлээлгэн, зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсний дараа энэ гэрээний 3.3.2 дахь заалт хамаарахгүй.
- 3.3.5. Энэ гэрээний 3.3.3-ын iii-д заасан ажлын тэйланд Захиалагчийг төлөөлж эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Хэрэв Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах хүсэлтийг



Захиалагчид бичгээр гаргаж өгснөөс хойш 28 /хорин найм/ хоногийн дотор Захиалагч баталгаажуулаагүй буюу Гүйцэтгэгчид бичгээр хариу мэдэгдээгүй бол тухайн тайлант ажлын гүйцэтгэлийг баталгаажуулсанд тооцохыг Захиалагч хүлээн зөвшөөрөв.

### 3.4. Захиалагчийн хяналтын болон магадалшгүй ажлын зардал:

- 3.4.1. Богдхан төмөр замын туннел, эстакадан гүүрний барилга угсралтын ажлын захиалагчийн хяналтын болон магадалшгүй ажлын зардал нь энэ гэрээний 3.1.1-т заасан үнийн дүнд багтсан бөгөөд Санхүүжүүлэгч нь тус зардал багтсан дүнгээр нүүрсийг Гүйцэтгэгчид нийлүүлнэ.
- 3.4.2. Гүйцэтгэгч нь нүүрсээр хүлээн авсан төслийн санхүүжилтээс ажлын гүйцэтгэлийн явц дундын төлбөрийн хүсэлтээр баталгаажсан ажлын гүйцэтгэлд ногдох захиалагчийн хяналтын зардлыг Захиалагчийн нэхэмжлэхийг үндэслэн Захиалагчид мөнгөн хөрөнгөөр шилжүүлнэ.
- 3.4.3. Магадалшгүй ажлын зардлын тооцоог Захиалагч болон Гүйцэтгэгчийн эрх бүхий этгээд хамтран баталгаажуулна.


## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. САНХҮҮЖҮҮЛЭГЧИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ЭРГЭН ТӨЛӨХ НӨХЦӨЛ

### 4.1. Санхүүжүүлэгчийн санхүүжилтийг эргэн төлөх нөхцөл:

- 4.1.1. Монгол Улсын Засгийн газрын зүгээс төслийн санхүүжилтийн эргэн төлөлттэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэх эсвэл төмөр замын эцсийн өмчлөгч төсөлд зарцуулсан нийт санхүүжилтийг эргэн төлөх хүртэлх хугацаанд Санхүүжүүлэгч нь энэ гэрээний дагуу олгосон санхүүжилтийг өөрийн компанийн балансад СТОУС-ын дагуу бүртгэнэ.
- 4.1.2. Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр “Богдхан төмөр зам”-ыг өөр этгээдийн өмчлөлд шилжүүлэх тохиолдолд санхүүжилтийн эргэн төлөлттэй холбоотой асуудлыг өмчлөлийг хүлээн авсан этгээдтэй Санхүүжүүлэгч гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 4.1.3. Монгол Улсын Засгийн газар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр Санхүүжүүлэгчээс төсөлд зарцуулсан нийт санхүүжилтийг Санхүүжүүлэгчид бүрэн эргэн төлөх асуудал шийдвэрлэгдсэнээр барилгын ажлын өмчлөгчийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, мөн талуудын хооронд үүссэн санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу балансаас балансад шилжүүлэх нөхцөл бүрдэнэ.

## ТАВДУГААР ЗҮЙЛ. САНХҮҮЖҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ



- 5.1. Санхүүжүүлэгч нь энэ гэрээний 3.1.1-д заасан хөрөнгийг өөрийн эзэмшлийн нүүрсний уурхайгаас олборлосон нүүрсийг Гүйцэтгэгч болон түүний нэрлэсэн



- худалдан авагчид нийлүүлэх замаар нөхөн төлөх үүрэгтэй. Нийлүүлэх нүүрсний хэмжээ, үнэ болон бусад нөхцөлтэй холбогдсон харилцааг энэ гэрээний "Хавсралт 3"-т заасан Санхүүжүүлэгч болон Гүйцэтгэгч түүний нэрлэсэн худалдан авагчийн хооронд байгуулах нүүрс нийлүүлэх гэрээгээр зохицуулна.
- 5.2. Санхүүжүүлэгчээс олгосон санхүүжилтийн зарцуулалтын болон ажлын гүйцэтгэлийн тайланг Захиалагч болон Гүйцэтгэгчээс улирал бүр шаардан авах эрхтэй.
  - 5.3. Санхүүжүүлэгч нь төслийн гүйцэтгэлтэй уялдуулан энэ гэрээний 3.1.1-д заасан үнийн дүнгээс бэлэн мөнгө болон бусад эх үүсвэрээр олгосон үнийн дүнг хассан хэмжээний нүүрсийг Гүйцэтгэгчид нийлүүлэх үүрэгтэй.
  - 5.4. Санхүүжүүлэгч нь төслийн ажилд шаардагдах гэрээний 3.1.1-д заасан санхүүжилтийг Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлтэй уялдуулан зохих ёсоор бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
  - 5.5. Санхүүжүүлэгч нь гэрээний хэрэгжилтэд хяналт тавих хүрээнд талуудын хооронд байгуулсан энэ гэрээний санхүүжилтийн зарцуулалт (гүйцэтгэл)-ыг хянан шалгах, санхүүжилттэй холбоотой тайлан, мэдээг Захиалагч болон Гүйцэтгэгчээс хууль, энэ гэрээнд заасны дагуу хэдийд ч гаргуулан авах, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн аудит хийлгэх эрхтэй.
  - 5.6. Энэ гэрээний дагуу Санхүүжүүлэгчийн хүлээсэн үүрэг, хариуцлага нь i) гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, ii) Санхүүжүүлэгч хуулийн этгээдийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц өөрчлөгдсөн, компанийн эрх, үүргийг шилжүүлсэн, iii) бусад нөхцөл байдал бий болсон эсэхээс үл хамааран хүчинтэй хэвээр үргэлжилнэ.
  - 5.7. Төслийн ажилд шаардагдах санхүүжилтийг Гүйцэтгэгч нь татан төвлөрүүлэхтэй холбоотойгоор олон улсын банк, санхүүгийн байгууллага, бусад хөрөнгө оруулагчаас шаардсан Санхүүжүүлэгчтэй холбоотой санхүүгийн болон бусад мэдээ мэдээлэл, баримт бичгийг Гүйцэтгэгчид гаргаж өгнө.
  - 5.8. Санхүүжүүлэгч нь энэ гэрээний хүрээнд Нүүрс нийлүүлэх гэрээний дагуу Гүйцэтгэгчид нийлүүлж буй нүүрсийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар тээвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
  - 5.9. Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

### ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Захиалагч нь Санхүүжүүлэгчээс шаардсан шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг тухай бүр Гүйцэтгэгчээс хүлээн авч, ажлын таван өдөрт багтаан хүргүүлнэ.
- 6.2. Захиалагч нь төслийн ажлын явц, гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Санхүүжүүлэгчид албан бичгээр мэдэгдэж, шийдвэрлүүлнэ.
- 6.3. Санхүүжүүлэгчээс олгосон санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих, бүтээн байгуулалтын ажлын явцад Захиалагчийн техникийн хяналтыг зохих журмын дагуу хийх үүрэгтэй.





- 6.4. Энэ гэрээний 5.2-д заасны дагуу Санхүүжүүлэгчээс шаардсан тайлан, төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл, бусад баримт бичгийг заасан хугацаанд, үнэн зөв бэлтгэж, баталгаажуулан хүргүүлэх үүрэгтэй.
- 6.5. Гэрээний хэрэгжилттэй холбогдуулан гаргасан Санхүүжүүлэгчийн хүсэлт, шаардлагын хариуг нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.
- 6.6. Энэ гэрээний 5.2-д заасны дагуу Санхүүжүүлэгч нь Захиалагчаар дамжуулан Гүйцэтгэгчээс шаардсан баримт бичиг, материалыг Гүйцэтгэгчээс тухай бүр түргэн шуурхай гаргуулах арга хэмжээг авч ажиллана.
- 6.7. Захиалагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь Санхүүжүүлэгч хамгийн сүүлд тооцоо нийлсний дараах дараагийн шатны санхүүжилтийг шийдвэрлэхгүй байх үндэслэл болно.
- 6.8. Санхүүжүүлэгчийн нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцүүлэн компанид ногдох төслийн үр ашиг болон хөрөнгө оруулалтын өгөөжийг тусгасан үнийн дүн бүхий санхүүжилтийг Санхүүжүүлэгчид эргэн төлөх талаарх саналыг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулах үүрэгтэй.
- 6.9. Төслийн ажилд шаардагдах санхүүжилтийг Гүйцэтгэгч нь татан төвлөрүүлэхтэй холбоотойгоор олон улсын банк, санхүүгийн байгууллага, бусад хөрөнгө оруулагчаас шаардсан Захиалагчтай холбоотой санхүүгийн болон бусад мэдээ мэдээлэл, баримт бичгийг Гүйцэтгэгчид гаргаж өгнө.
- 6.10. Захиалагч нь энэ гэрээний хүрээнд Нүүрс нийлүүлэх гэрээний дагуу Гүйцэтгэгчид нийлүүлж буй нүүрсийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар тээвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 6.11. Энэ гэрээний дагуу Захиалагчийн хүлээсэн үүрэг, хариуцлага нь i) гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, ii) Захиалагчийн хуулийн этгээдийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц өөрчлөгдсөн, компанийн эрх, үүргийг шилжүүлсэн, iii) бусад нөхцөл байдал бий болсон эсэхээс үл хамааран хүчинтэй хэвээр үргэлжилнэ.
- 6.12. Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

### ДОЛДУГААР ЗҮЙЛ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1. Гүйцэтгэгч нь “Богдхан төмөр зам”-ын туннел болон эстакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээнд заасан ажлыг энэ гэрээнд заасан санхүүжилтийн дүн, техникийн үзүүлэлт болон ажлын гүйцэтгэлийн хуваарийн дагуу гүйцэтгэх үүрэгтэй.
- 7.2. Гүйцэтгэгч нь Санхүүжүүлэгчтэй байгуулсан нүүрс нийлүүлэх гэрээ /мөн нэрлэсэн худалдан авагчтай байгуулсан гэрээ/-ний санхүүжилттэй уялдуулан төслийн ажилд шаардагдах хөрөнгийг урьдчилан санхүүжүүлэх замаар ажлыг саадгүй гүйцэтгэх үүрэгтэй.
- 7.3. Гүйцэтгэгч нь хуулийн дагуу өөрийн төлөх шаардлагатай бүхий л татвар, хураамж, төлбөрийг төлнө.
- 7.4. Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэх үүргээ биелүүлээгүй нь Санхүүжүүлэгч нь талуудын сүүлийн тооцоо нийлсэн актыг үйлдсэн өдрөөс

6373405 49 CBAA1780  
Тавантолгой  
ХХК

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХХК  
ХЭЗГ  
№01

МОНГОЛ УЛС  
BODI INTERNATIONAL LLC  
БОДЬ ИНТЕРНАЦИОНАЛ  
ХХК  
УТГОМГ  
ТТА1515 2040430

хойш бий болсон дараагийн шатны санхүүжилтийг шийдвэрлэхгүй байх үндэслэл болно.



- 7.5. Гэрээний хүрээнд холбогдуулан гаргасан Санхүүжүүлэгч болон Захиалагчийн хүсэлт, шаардлагын хариуг нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.
- 7.6. Санхүүжүүлэгчээс энэ гэрээний дагуу шаардсан бичиг баримтуудыг үнэн зөвөөр бэлтгэн ажлын 5 өдрийн дотор Захиалагчид хүргүүлэн, Захиалагчаар дамжуулан гаргаж өгөх үүрэгтэй.
- 7.7. Төслийн ажлын санхүүжилт ба гүйцэтгэлд хөндлөнгийн аудит хийлгэсэн тохиолдолд тухайн аудитын байгууллагын шаардсан бүхий л мэдээ мэдээллийг нэн даруй гаргаж өгөх үүрэгтэй.
- 7.8. Төслийн барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулахтай холбоотой асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцна.
- 7.9. Энэ гэрээний Удиртгал хэсэгт дурдсан Монгол Улсын Засгийн газрын тогтоол, бусад шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж, өөрсдөөс хамаарах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн төлөө бусад талуудтай шуурхай хамтран ажиллана.
- 7.10. Энэ гэрээний дагуу олгосон санхүүжилтийг энэ гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна.
- 7.11. Энэ гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг, хариуцлага нь i) гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, ii) Гүйцэтгэгч нь хуулийн этгээдийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц өөрчлөгдсөн, компанийн эрх, үүргийг шилжүүлсэн, iii) бусад нөхцөл байдал бий болсон эсэхээс үл хамааран хүчинтэй хэвээр үргэлжилнэ.
- 7.12. Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

### НАЙМДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА




- 8.1. Энэ гэрээ нь талууд харилцан зөвшилцөж гарын үсэг зурсан өдрөөс эхлэн барилга угсралтын ажлыг 100 хувь гүйцэтгэж, ажлын үр дүнг Улсын комисст хүлээлгэн өгч, энэ гэрээний дагуу Гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг бүрэн төлж дуустал хугацаанд хүчинтэй байна.

### ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. МЭДЭГДЭЛ, БАТАЛГАА

- 9.1. Санхүүжүүлэгч нь дараах мэдэгдэл, баталгаа гаргаж байна:
  - 9.1.1. Санхүүжүүлэгч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор үүсгэн байгуулагдсан, хууль ёсоор оршин тогтнож байгаа төрийн өмчийн оролцоотой компани бөгөөд энэхүү гэрээг байгуулах, гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хууль ёсны бүрэн эрхтэй;
  - 9.1.2. Санхүүжүүлэгч нь энэ гэрээг байгуулах, гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээ (Засгийн газраас авах шаардлагатай бүх зөвшөөрлийг авах зэрэг)-г авсан бөгөөд энэ гэрээний





- нөхцөл, заалтууд нь Санхүүжүүлэгчийн хувьд хэрэгжүүлэх боломжтой, хүчин төгөлдөр, хууль ёсны заавал биелүүлэх үүргийг бий болгоно;
- 9.1.3. Энэ гэрээг байгуулах, хэрэгжүүлэх нь Санхүүжүүлэгчийн үүсгэн байгуулах баримт бичигт заасан нөхцөл, шаардлагуудтай зөрчилдөхгүй;
- 9.1.4. Санхүүжүүлэгч нь Тавантолгойн ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл болон уул уурхайн үйл ажиллагаа явуулах эрхийг аливаа барьцаанаас ангид, чөлөөтэй эзэмшдэг. Ашиглалтын тусгай зөвшөөрөл болон уул уурхайн үйл ажиллагаа явуулах эрх нь хүчин төгөлдөр болно. Санхүүжүүлэгч нь Тавантолгойн ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дагуу эдэлж байгаа аливаа эрх гуравдагч этгээдэд худалдаагүй, бусад хэлбэрээр шилжүүлээгүй бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрлийн дагуу Санхүүжүүлэгч-ийн эдэлж байгаа эрхтэй холбоотойгоор аливаа гуравдагч этгээдийн шаардлага, эрх, бусад төрлийн ашиг сонирхол байхгүй болно;
- 9.1.5. Санхүүжүүлэгч нь Тавантолгойн ордтой холбоотой газрын эрхийг эзэмшдэг бөгөөд Газар эзэмших, ашиглах гэрээ нь энэхүү гэрээг байгуулах өдрийн байдлаар хүчин төгөлдөр, цуцлагдаагүй байна. Санхүүжүүлэгч нь Газар эзэмших, ашиглах гэрээний дагуу эдэлж байгаа Таван толгойн орд газартай холбоотой аливаа эрхээ худалдаагүй, бусад хэлбэрээр гуравдагч этгээдэд шилжүүлээгүй байна;
- 9.1.6. Энэ гэрээг байгуулах, хэрэгжүүлэх нь i) Санхүүжүүлэгч нэг тал нь болж байгуулагдсан, эсхүл түүний эд хөрөнгийн эрх хөндөгдөж байгаа гэрээ хэлцэл, баримт бичгийн дагуу үүргийн зөрчлийг бий болгохгүй, зөрчилд хүргэхгүй, ii) аливаа шүүх, арбитр, төр, засгийн газрын байгууллагын тушаал, шийдвэр, захирамж, тогтоолтой зөрчилдөхгүй, зөрчилд хүргэхгүй болно;
- 9.1.7. Санхүүжүүлэгч нь хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон, шинээр батлагдсан, эсхүл Засгийн газар болон хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрийн улмаас татан буугдах, үйл ажиллагааг нь зогсоох, өөр хуулийн этгээдтэй нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх, эсхүл хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх зэрэг Захиалагч, Гүйцэтгэгчийн эрх ашиг хөндөгдөж болзошгүй аливаа нөхцөл байдал үүсвэл энэ тухай түүнд нэн даруй мэдэгдэнэ.
- 9.2. Захиалагч нь дараах мэдэгдэл, баталгаа гаргаж байна:
- 9.2.1. Захиалагч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор үүсгэн байгуулагдсан, хууль ёсоор оршин тогтнож байгаа төрийн өмчийн компани бөгөөд энэхүү гэрээг байгуулах, гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хууль ёсны бүрэн эрхтэй;
- 9.2.2. Захиалагч нь энэ гэрээг байгуулах, гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээ (Засгийн газраас авах шаардлагатай бүх зөвшөөрлийг авах зэрэг)-г авсан бөгөөд энэхүү гэрээний нөхцөл, заалтууд нь Захиалагчийн хувьд хэрэгжүүлэх боломжтой, хүчин төгөлдөр, хууль ёсны заавал биелүүлэх үүргийг бий болгоно;



- 9.2.3. Энэ гэрээг байгуулах, хэрэгжүүлэх нь Захиалагчийн үүсгэн байгуулах баримт бичигт заасан нөхцөл, шаардлагуудтай зөрчилдөхгүй;
- 9.2.4. Энэ гэрээг байгуулах, хэрэгжүүлэх нь i) Захиалагч нэг тал нь болж байгуулагдсан, эсхүл түүний эд хөрөнгийн эрх хөндөгдөж байгаа гэрээ хэлцэл, баримт бичгийн дагуу үүргийн зөрчлийг бий болгохгүй, зөрчилд хүргэхгүй, ii) аливаа шүүх, арбитр, төр, засгийн газрын байгууллагын тушаал, шийдвэр, захирамж, тогтоолтой зөрчилдөхгүй, зөрчилд хүргэхгүй болно;
- 9.2.5. Захиалагч нь хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон, шинээр батлагдсан, эсхүл Засгийн газар болон хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрийн улмаас хуульд заасан үндэслэлээр татан буугдах, үйл ажиллагааг нь зогсоох, өөр хуулийн этгээдтэй нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх, эсхүл хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх зэрэг Санхүүжүүлэгч, Гүйцэтгэгч талын эрх ашиг хөндөгдөж болзошгүй аливаа нөхцөл байдал үүсвэл энэ тухай түүнд нэн даруй мэдэгдэнэ.

9.3. Гүйцэтгэгч нь дараах мэдэгдэл, баталгаа гаргаж байна:

- 9.3.1. Гүйцэтгэгч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор үүсгэн байгуулагдсан, хууль ёсоор оршин тогтнож байгаа компани бөгөөд энэхүү гэрээг байгуулах, гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хууль ёсны бүрэн эрхтэй;
- 9.3.2. Гүйцэтгэгч нь энэ гэрээг байгуулах, гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээ (Засгийн газраас авах шаардлагатай бүх зөвшөөрлийг авах зэрэг)-г авсан бөгөөд энэхүү гэрээний нөхцөл, заалтууд нь Гүйцэтгэгчийн хувьд хэрэгжүүлэх боломжтой, хүчин төгөлдөр, хууль ёсны заавал биелүүлэх үүргийг бий болгоно;
- 9.3.3. Энэ гэрээг байгуулах, хэрэгжүүлэх нь Гүйцэтгэгчийн үүсгэн байгуулах баримт бичигт заасан нөхцөл, шаардлагуудтай зөрчилдөхгүй.
- 9.3.4. Энэ гэрээг байгуулах, хэрэгжүүлэх нь i) Гүйцэтгэгч нэг тал нь болж байгуулагдсан, эсхүл түүний эд хөрөнгийн эрх хөндөгдөж байгаа гэрээ хэлцэл, баримт бичгийн дагуу үүргийн зөрчлийг бий болгохгүй, зөрчилд хүргэхгүй, ii) аливаа шүүх, арбитр, төр, засгийн газрын байгууллагын тушаал, шийдвэр, захирамж, тогтоолтой зөрчилдөхгүй, зөрчилд хүргэхгүй болно;
- 9.3.5. Гүйцэтгэгч нь хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон, шинээр батлагдсан, эсхүл Засгийн газар болон хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрийн улмаас хуульд заасан үндэслэлээр татан буугдах, үйл ажиллагааг нь зогсоох, өөр хуулийн этгээдтэй нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх, эсхүл хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх зэрэг Санхүүжүүлэгч, Захиалагчийн эрх ашиг хөндөгдөж болзошгүй аливаа нөхцөл байдал үүсвэл энэ тухай түүнд нэн даруй мэдэгдэнэ.



**АРАВДУГААР ЗҮЙЛ.  
НУУЦЛАЛ**




- 10.1. Энэ гэрээний нөхцөл, заалт нь нууц байх бөгөөд хуулийн дагуу төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд Талуудын бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй.
- 10.2. Гүйцэтгэгч нь төслийн санхүүжилтийг бусад эх үүсвэрээс татан төвлөрүүлэх зорилгоор олон улсын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчдаас шаардсан тохиолдолд гэрээний бусад талуудад бичгээр мэдэгдсэнээр энэ гэрээний 10.1-д заасан мэдээллийг гаргаж өгнө.

**АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.  
ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ЭРХ, ҮҮРЭГ БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ**

- 11.1. Талууд нь энэ гэрээний дагуу хүлээсэн эрх, үүргээ Засгийн газрын шийдвэр, зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

**АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ.  
ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

- 12.1. Давагдашгүй хүчин зүйл гэж Талуудын санаатай буюу болгоомжгүй буруутай үйлдэл, эс үйлдлээс үл хамаарах, түүнийг урьдчилан мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бөгөөд түүнийг даван туулах, эсхүл зайлуулах буюу үр дагаврыг нь бууруулах боломжгүйгээс гэрээний үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон дараахь нөхцөл байдлыг ойлгоно:
- 12.1.1. үер, газар хөдлөлт, хөрсний гулгалт, гал түймэр, хүчтэй шуурга, аадар бороо, эрс хүйтрэлт, цаг агаарын гэнэтийн ноцтой үзэгдэл зэрэг байгалийн гамшигт нөхцөл байдал;
- 12.1.2. тахал, халдварт өвчин буюу хорио цээр, түүнчлэн гадаад улсын болон дотоодын төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хил, авто болон төмөр замын харилцааг хаах, эсхүл түр зогсоох, импорт, экспортын хориг, хязгаарлалт тавьсан;
- 12.1.3. дайн, онц байдал, түрэмгийлэл, зэвсэгт мөргөлдөөн болон гадны халдлага, бүслэлт, худалдааны хориг, хувьсгал;
- 12.1.4. улс даяар өрнөсөн, эсхүл салбар, Талуудын үйл ажиллагааг хамарсан ажил хаялт, улс төрийн жагсаал, цуглаан, бослого.
- 12.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлж чадаагүйгээс үүссэн үр дагаврыг Талууд хариуцахгүй. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлж чадаагүй нөхцөл байдлыг гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүний үргэлжлэх хугацаанд тухайн үүргийн гүйцэтгэл болон цаг хугацааны шаардлагыг түр зогссон гэж үзнэ.
- 12.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болсон тал нь энэ тухай болон түүний шалтгааны талаар уг хүчин зүйл бий болсон хугацаанаас хойш ажлын 5 /тав/ хоногийн дотор нөгөө талдаа




- бичгээр шуурхай мэдэгдэх бөгөөд Талууд шалтгааныг арилгах боломжтой бүхий л арга хэмжээг авахын зэрэгцээ түүнийг арилгахын төлөө хамтран ажиллана. Мэдэгдэлд дараах мэдээллийг заавал тусгана:
- 12.3.1. шинж чанар, нөлөөлөл, хамрах хүрээний талаархи нотлох баримт бүхий мэдээлэл;
  - 12.3.2. үргэлжлэх хугацаа, эсхүл энэ талаарх таамаг;
  - 12.3.3. гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлд саад учруулах, эсхүл саад учруулж болзошгүй нөлөөллийн талаархи таамаг;
  - 12.3.4. давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл, учруулах хохирлын хэмжээг багасгах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа, эсхүл авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээ;
  - 12.3.5. холбогдох бусад мэдээлэл.
- 12.4. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл цар хүрээнээс илүү хэмжээгээр буюу түүний үргэлжлэх хугацаанаас урт хугацаагаар гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хойшлуулахгүй.
- 12.5. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан зардлыг Талууд тус бүр өөрсдөө хариуцна.

### АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 13.1. Гэрээнээс үүдэлтэй буюу түүнтэй холбоотойгоор Талуудын хооронд аливаа маргаан гарвал түүнийг эхний ээлжинд хэлэлцэн тохиролцож шийдвэрлэх бөгөөд аль нэг тал нь хэлэлцээ хийх хүсэлтийг бичгээр тавьснаас хойш ажлын 30 /гуч/ хоног, эсхүл харилцан тохиролцсон түүнээс дээш, тодорхой хугацааны дотор Талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол уг маргааныг энэ гэрээний 13.2-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 13.2. Талууд маргаанаа энэ гэрээний 13.1-д заасны дагуу шийдвэрлэж чадаагүй бол энэ гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг цуцлах, дуусгавар болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын ба үндэсний арбитраар Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 13.3. Арбитрчдын тоо 3 /гурав/ байна. Арбитрын шүүх ажиллагааг Монголын олон улсын ба үндэсний арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу явуулна.
- 13.4. Арбитрын шийдвэр эцсийнх байна.

### АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ХАРИУЦЛАГА

- 14.1. Талууд өөрийн шийдвэр, үйл ажиллагааны улмаас, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талуудад учруулсан хохирлыг хариуцан арилгаж, хохиролгүй болгоно.
- 14.2. Санхүүжүүлэгч "Хавсралт 1"-д заасан хуваарийн дагуу нүүрс нийлүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Гүйцэтгэгч талд зохих ёсоор гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,0001 хувиар хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцож Гүйцэтгэгчид төлнө. Алдангийн нийт хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байна.
- 14.3. Захиалагч нь энэ гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Гүйцэтгэгч талд зохих ёсоор гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,0001 хувиар




- хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцож Гүйцэтгэгчид төлнө. Алдангийн нийт хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байна.
- 14.4. Гүйцэтгэгч нь урьдчилан санхүүжүүлэх үүргээ биелүүлээгүйн улмаас төслийн ажлыг хоцроосон, зогсоосон бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,0001 хувиар хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги тооцож Санхүүжүүлэгчид төлнө. Алдангийн нийт хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байна.
- 14.5. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн нөхцөл байдалд энэ гэрээний 14 дүгээр зүйлд заасан хариуцлага хамаарахгүй болно.

### АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- 15.1. Энэ гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болно:
- 15.1.1. энэ гэрээний 3.1.3, 3.2.2-д заасан нүүрс нийлүүлэх гэрээ байгуулагдаагүй;
- 15.1.2. энэ гэрээний 3.2.1-д заасан мөнгөн хөрөнгийг санхүүжилтийн хуваарийн дагуу татан төвлөрүүлж чадаагүйн улмаас барилгын ажил 3 сараас дээш хугацаагаар зогссон;
- 15.1.3. энэ гэрээний 8.1-д заасан хугацаа дууссан бөгөөд Талууд энэ гэрээ болон мөн гэрээний “Хавсралт 3”-д заасан нүүрс нийлүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
- 15.1.4. Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулагдсан “Богдхан төмөр зам”-ын туннел болон эстакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ болон Санхүүжүүлэгч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулагдсан Нүүрс нийлүүлэх гэрээ бүрэн хэрэгжсэн;
- 15.1.5. энэ гэрээнд заасан тохиолдол үүссэн бол.
- 15.2. Энэ гэрээг дуусгавар болгох нь гэрээний аль нэг тал энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд гэрээг дуусгавар болгохоос өмнө оруулсан бүх хөрөнгө оруулалтад хамаарах төлбөрийн үүргээ бүрэн биелүүлэх хүртэл хэвээр үлдэнэ.
- 15.3. Гэрээний хугацаа дуусгавар болсноос хойш 30 /гуч/ хоногийн дотор Талууд тооцоо нийлсэн баримтад гарын үсэг зурж баталгаажуулан Гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

### АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. БУСАД ЗҮЙЛ

- 16.1. Гэрээний дагуу аливаа мэдэгдэл, бусад харилцаа холбоог Талууд бичгээр үйлдэн биечлэн, эсхүл шуудан, факсаар илгээнэ. Шуудангийн хураамж, илгээлтийн төлбөрийг урьдчилан бүрэн төлсөн байдлаар доор дурдсан хаягаар хүргэгдсэнээр тухайн баримт бичгийг зохих ёсоор хүлээлгэн өгсөн гэж тооцно:



**Санхүүжүүлэгч:****Нэр:** “Эрдэнэс Тавантолгой” ХК**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж -8, Финанс төв.**Утас:** (976) 75055555**Факс:** (976) 75055555**Цахим шуудан:** \_\_\_\_\_**Захиалагч ХХК:****Нэр:** “Тавантолгой Төмөр Зам” ХХК**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар дүүрэг, 13-р хороолол, Нарны зам-62, Юнион Бюлдинг Б блок, 11 давхар.**Утас:** (976)-77777877**Факс:** (976)-77771777**Цахим шуудан:** [info@ttz.mn](mailto:info@ttz.mn)**Гүйцэтгэгч:****Нэр:** “Бодь Интернэшнл” ХХК**Хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-24, “Парк Плэйс” оффис, 3 давхар.**Утас:** (976) 70139966**Цахим шуудан:** [tavantolgoi@bodigroup.com](mailto:tavantolgoi@bodigroup.com)

- 16.2. Энэ гэрээний 16.1-д заасан хаяг өөрчлөгдвөл тухайн тал 24 /хорин дөрвөн/ цагийн дотор шинэ хаягаа нөгөө талуудад мэдэгдэнэ. Аль нэг тал нь гэрээний дагуу явуулсан мэдэгдлийг хүлээж авахаас татгалзсан, эсхүл хүлээн авах боломжгүй байсан нь нөгөө талын эрхийг хязгаарлах, хохироох үндэслэл болохгүй.
- 16.3. Энэ гэрээг монгол хэл дээр 3 (гурав) эх хувь үйлдсэн бөгөөд Талууд тус бүр 1 (нэг) хувийг хадгална.
- 16.4. Энэ гэрээний хавсралт нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.
- 16.5. Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулна.
- 16.6. Энэ гэрээ нь дараах хавсралттай байна:
- |                    |   |
|--------------------|---|
| 16.6.1. Хавсралт 1 | Богдхан төмөр замын туннел болон эстакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн хуваарь; |
| 16.6.2. Хавсралт 2 | Гүйцэтгэгчийн оруулсан хөрөнгийг нөхөн төлөх/явц дундын болон эцсийн төлбөрийн хуваарь;                               |
| 16.6.3. Хавсралт 3 | Нүүрс нийлүүлэх гэрээ.  |

Дээрхийг нотлон энэ гэрээнд Талуудыг төлөөлж эрх бүхий дараах албан тушаалтнууд Улаанбаатар хотноо гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болов.

ХЭЗГ

-----oOo-----





НУУЦ  
"БОДЬ ИНТЕРНЭШНЛ" ХХК

МАШ НУУЦ  
ИЛ БОЛСОН

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
.....  
Б.ГАНХУЯГ



"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
.....  
Н.УДААНЖАРГАЛ



"БОДЬ ИНТЕРНЭШНЛ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
.....  
Б.ДОЛГОРМАА






"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК  
ХЭЗГ  
№01

Богдхан төмөр замын туннел болон эстакадан гүүрний  
зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын  
санхүүжилтийн гэрээний  
"ХАВСРАЛТ 1"

**БОГДХАН ТӨМӨР ЗАМЫН ТУННЕЛ БОЛОН ЭСТАКАДАН ГҮҮРНИЙ  
ЗУРАГ ТӨСӨЛ, ХУДАЛДАН АВАЛТ, БАРИЛГЫН  
АЖЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ**

№	Он	Сар	Шаардлагатай санхүүжилтийн дүн (ам.доллараар)
1	2022	6	\$1,354,320.00
2	2022	7	\$526,680.00
3	2022	8	\$38,479,805.10
4	2022	9	\$526,680.00
5	2022	10	\$110,042,493.55
6	2022	11	\$10,647,513.36
7	2022	12	\$95,890,187.42
<b>2022 он</b>			<b>\$257,467,679.43</b>
8	2023	1	\$24,675,709.78
9	2023	2	\$27,801,682.05
10	2023	3	\$27,373,374.13
11	2023	4	\$27,675,171.64
12	2023	5	\$27,850,458.72
13	2023	6	\$27,962,490.60
14	2023	7	\$27,821,501.64
15	2023	8	\$25,587,749.76
16	2023	9	\$18,152,592.23
17	2023	10	\$18,741,708.70
18	2023	11	\$19,612,803.08
19	2023	12	\$19,977,855.79
<b>2023 он</b>			<b>\$293,233,098.12</b>
20	2024	1	\$10,378,249.84
21	2024	2	\$6,337,509.37
22	2024	3	\$6,210,998.95
23	2024	4	\$6,337,509.37
24	2024	5	\$7,096,571.87
25	2024	6	\$7,223,082.29
26	2024	7	\$6,084,488.53
27	2024	8	\$5,957,978.12
28	2024	9	\$5,957,978.12
29	2024	10	\$6,970,061.45
30	2024	11	\$6,970,061.45
31	2024	12	\$6,970,061.45
<b>2024 он</b>			<b>\$82,494,550.80</b>
32	2025	1	\$6,590,530.20



33	2025	2	\$6,590,530.20
34	2025	3	\$6,970,061.45
35	2025	4	\$6,464,019.78
36	2025	5	\$6,464,019.78
37	2025	6	\$4,439,853.11
38	2025	7	\$3,339,592.13
39	2025	8	\$3,578,134.42
40	2025	9	\$3,697,405.57
41	2025	10	\$4,508,449.37
42	2025	11	\$3,435,009.05
43	2025	12	\$3,053,341.37
<b>2025 он</b>			<b>\$59,130,946.45</b>
44	2026	1	\$3,983,656.32
45	2026	2	\$3,315,737.90
46	2026	3	\$3,721,259.80
47	2026	4	\$3,244,175.21
48	2026	5	\$3,554,280.19
49	2026	6	\$3,363,446.36
50	2026	7	\$3,220,320.98
51	2026	8	\$3,172,612.52
52	2026	9	\$3,172,612.52
53	2026	10	\$3,864,385.18
54	2026	11	\$3,864,385.18
55	2026	12	\$3,816,676.72
<b>2026 он</b>			<b>\$42,293,548.87</b>
<b>Нийт</b>			<b>\$734,619,823.67</b>

\* Санхүүжилтийн хуваарьт төслийн ажил гүйцэтгэх төлөвлөгөөтэй уялдаж өөрчлөлт орж болно.

\*\* Захиалагчид хүргүүлсэн ажлын тайланд тусгагдсан бодит гүйцэтгэлээр урьдчилан санхүүжүүлсэн мөнгөн дүнг тодорхойлно.

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК  
ХЭЗГ  
№01

-----oOo-----



Богдхан төмөр замын туннел болон эстакадан гүүрний  
зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын  
санхүүжилтийн гэрээний  
"ХАВСРАЛТ 2"

**ГҮЙЦЭТГЭГЧИЙН ОРУУЛСАН ХӨРӨНГИЙГ НӨХӨН ТӨЛӨХ/ЯВЦ ДУНДЫН  
БОЛОН ЭЦСИЙН ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ**

Т	Он	Сар	Санхүүжилтийн дүн	Тоо хэмжээ (тонн)
1	2022	8	\$ 12,243,663.73	
	2022	9	\$ 12,243,663.73	
2	2022	10	\$ 12,243,663.73	
	2022	11	\$ 12,243,663.73	
	2022	12	\$ 12,243,663.73	
<b>2022 он нийт</b>			<b>\$ 61,218,318.65</b>	
3	2023	1	\$ 12,243,663.73	
	2023	2	\$ 12,243,663.73	
	2023	3	\$ 12,243,663.73	
4	2023	4	\$ 12,243,663.73	
	2023	5	\$ 12,243,663.73	
	2023	6	\$ 12,243,663.73	
5	2023	7	\$ 12,243,663.73	
	2023	8	\$ 12,243,663.73	
	2023	9	\$ 12,243,663.73	
6	2023	10	\$ 12,243,663.73	
	2023	11	\$ 12,243,663.73	
	2023	12	\$ 12,243,663.73	
<b>2023 он нийт</b>			<b>\$ 146,923,964.73</b>	
7	2024	1	\$ 12,243,663.73	
	2024	2	\$ 12,243,663.73	
	2024	3	\$ 12,243,663.73	
8	2024	4	\$ 12,243,663.73	
	2024	5	\$ 12,243,663.73	
	2024	6	\$ 12,243,663.73	
9	2024	7	\$ 12,243,663.73	
	2024	8	\$ 12,243,663.73	
	2024	9	\$ 12,243,663.73	
10	2024	10	\$ 12,243,663.73	
	2024	11	\$ 12,243,663.73	
	2024	12	\$ 12,243,663.73	
<b>2024 он нийт</b>			<b>\$ 146,923,964.73</b>	
11	2025	1	\$ 12,243,663.73	
	2025	2	\$ 12,243,663.73	
	2025	3	\$ 12,243,663.73	
12	2025	4	\$ 12,243,663.73	
	2025	5	\$ 12,243,663.73	

ЭРДЭНЭС ТАВАНТӨЛГӨЙ  
ТӨМӨР ЗАМ  
ХХК  
1119279488  
УЛААНБААТАР ХТ

"ЭРДЭНЭС ТАВАНТӨЛГӨЙ" ХК  
ХЭЗГ  
№01

МОНГОЛ УЛС  
БОДИ ИНТЕРНАЦИОНАЛ  
ХХК  
ТТА1515 № 2010433

	2025	6	\$ 12,243,663.73	
13	2025	7	\$ 12,243,663.73	
	2025	8	\$ 12,243,663.73	
	2025	9	\$ 12,243,663.73	
14	2025	10	\$ 12,243,663.73	
	2025	11	\$ 12,243,663.73	
	2025	12	\$ 12,243,663.73	
<b>2025 он нийт</b>			<b>\$ 146,923,964.73</b>	
15	2026	1	\$ 12,243,663.73	
	2026	2	\$ 12,243,663.73	
	2026	3	\$ 12,243,663.73	
16	2026	4	\$ 12,243,663.73	
	2026	5	\$ 12,243,663.73	
	2026	6	\$ 12,243,663.73	
17	2026	7	\$ 12,243,663.73	
	2026	8	\$ 12,243,663.73	
	2026	9	\$ 12,243,663.73	
18	2026	10	\$ 12,243,663.73	
	2026	11	\$ 12,243,663.73	
	2026	12	\$ 12,243,663.73	
<b>2026 он нийт</b>			<b>\$ 146,923,964.73</b>	
19	2027	1	\$ 12,243,663.73	
	2027	2	\$ 12,243,663.73	
	2027	3	\$ 12,243,663.73	
20	2027	4	\$ 12,243,663.73	
	2027	5	\$ 12,243,663.73	
	2027	6	\$ 12,243,663.73	
21	2027	7	\$ 12,243,663.73	
<b>2027 он нийт</b>			<b>\$ 85,705,646.11</b>	
<b>Нийт</b>			<b>\$ 734,619,823.67</b>	

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК  
ХЭЗГ  
№01

-----oOo-----

